

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Мандал голомт” ХХК-ийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 93 тоот тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Мандал голомт” ХХК (С.Дарамдад)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 467 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах хязгаарт багтаан тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,649.6	
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	44,582.7
		тогтмол	Төг/м ³	1,484.5
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,304.0	
	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ	38,767.6
		тогтмол	Төг/м ³	1,290.9
3	Төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/Гкал	3,500.0	
		Төг/м ³	2,560.0	
		Төг/хүн	3,840.0	
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,024.0	
5	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	41 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000.0
		41-81м ² талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0
		81 м ² -с дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0